

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж буй эрчүүдийн албадан сургалт ба эдгэрлийн зан үйлийг Ж.П.Сартрын экзистенциал философийн үүднээс шинжлэх нь

Б.Баатарзоригт, магистрант

Ц.Нямсүрэн, доктор (Ph.D), дэд профессор
МУИС, Философи шашин судлалын тэнхим

Хураангуй: Энэ өгүүлэлдээ бид гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн эрчүүд “хүчирхийлэгч” гэсэн статусаас ангижирч, сэтгэл зүйн хувьд эдгэрэн, өөрийгөө ойлгох, амьдралыг харах өөр хандлагатай болж, нийгмийн амьдралд шинэ байр суурьтай оролцоход нь туслах давал давах зан үйлийн⁷ эерэг нөлөө, “коммунитас (communitas)” буюу ижил завсрын нөхцөл байдалд байгаа (liminal) нэгнийгээ ойлгож, эдгэрэхэд урам зориг өгөх бололцоог авч үзнэ. Түүнчлэн хүчирхийлэл үйлдсэн эрчүүдийн бүлэг нь гэр бүлийн хүчирхийллийг буруулах, амьдралаа өөрчлөх шийдвэр гаргахад нь нөлөөтэй байж болохыг антропологи, нийгмийн ажил, экзистенциал философийн үүднээс шинжилсэн болно.

Түлхүүр үг: гэр бүлийн хүчирхийлэл, давал давах, зан үйл, экзистенциализм, хүчирхийлэгч, эдгэрэл

Оршил

Антропологич, философич, лам хуврагаас эхлээд домч, урлаг, хүн судлалын мэргэжилтэн хүртэл олон төлөөлөгч аливаа зан үйлийг (ritual) үйлдэх, тэрхүү зан үйлээс үүдэн бий болж байгаа утга, илгээмж нь зан зүйлийг үйлдэж байгаа хүний амьдралд өөрчлөлт авчраад зогсохгүй, түүнийг ажиглаж байгаа хөндлөнгийн хүмүүст ч нөлөөлж, өөр хоорондоо холбогдох боломжийг нээдэг болохыг мэддэг байжээ. Энэ утгаараа зан үйлд суурилсан сургалт нь гэр бүлийн хүчирхийлэл (ГБХ) үйлдсэн эрчүүдийн өөрийгөө ойлгох ойлголтод нь гүн бат суусан “хүчирхийлэгч, гэмт хэрэгтэн” буюу үзэн ядагдсан, гадуурхагдсан, буруутгагдсан гэсэн статусаа орхин, амьдралдаа бүтээлч хандан эдгэрэхэд нь туслах үр дүнтэй байж болно.

Ингэхдээ статусын шилжилтэд нөлөөлдөг антроплогийн зан үйлийн онолыг тайлбарлаж, ГБХ үйлдсэн эрчүүдийн эдгэрэлд энэхүү онолыг ашиглан бүтээсэн сургалтын хөтөлбөр байх бололцооны тухай товч дурдан, улмаар ГБХ үйлдсэн эрчүүдийн статусын шилжилт нь экзистенциал нөхцөл байдалтай хэрхэн давхцаж байгааг шинжлэх болно.

Антропологи ба зан үйл

Антропологич Арнолд ван Геннеп (1960), В.Түрнер (1969) нар аливаа соёлд хүмүүс нийгмийн байр сууриа өөрчлөхдөө тодорхой давал давах зан үйл үйлдэн, дараагийн шинэ байр сууриа олж авдаг нийтлэг зүй тогтол байгааг анзаарч, энэ үйл явцын үе шатуудыг нарийвчлан судалсан байна. Түрнерийн үзэж байгаагаар шинэ статус олж авахын тулд зан үйлийн ангижралт (separation)⁸, лиминал төлөв (liminality), хамтын ажиллагаа (cooperation) гэсэн гурван үе шатыг даван гарах ёстой. Тухайн хүн нэгд зан үйлээр дамжуулан өмнөх амьдралын хэв маягаа орхиж, дараа нь лиминал төлөв буюу үүрэг, хариуцлага нь тодорхой болоогүй, ямар статустай болох нь мэдэгдэхгүй, айдас, түгшүүртэй шилжилтийн (transactional) статустай⁹ болдог.

Өөрөөр хэлбэл гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн эрчүүд албадан сургалтад хамрагдаж байх үедээ ийм лиминал статустай болдог ажээ. Хоригдож, албадан сургалтад хамрагдах үедээ хүчирхийлэгч биш боловч ирээдүйд хэн болох нь тодорхойгүй тийм төлөв байдал юм. Энэ үед,

⁷ Rites of Passage-давал давах зан үйл

⁸ Энд ерөнхий боловсролын сургуулийн сурагч сургуулиа төгсөн, сурагч статусаасаа орхиж байгаа шилжилтийг ойлгож болно.

⁹ Жишээ нь хонхны баяраа хийж сургуулиа төгссөн боловч хараахан их сургууль, ажилд ороогүй тодорхойгүй завсрын статус үүнд хамаарна.

Түрнерийн “коммунитас” гэдэг ойлголт чухал үүрэгтэй. Ижил нөхцөл байдалд, ижил өөрчлөлтийг мэдрч байгаа буюу лиминал төлөвт байгаа хүмүүс өөр хоорондоо хүчтэй холбогдон хамтдаа өөрсдийн шинэ статус, амьдралын хэв маяг бий болгох зан үйлүүдийг бүтээж, үүгээрээ дахин нийгмийн нэг хэсэг болж, байр сууриа олох үйл явцыг Түрнер коммунитас гэдгээр илэрхийлжээ. Ийм коммунитас бүрдүүлэх нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн эрчүүд дахин нийгмийн гишүүн болох гол арга зам байж болох юм.

Аливаа зан үйлийг нийгэмд аюултай хэмээн хориглож байгаа үүнийг халж чадах өөр зан үйлийг санал болгохгүйгээр тухайн аюултай зан үйл буурна гэж хүлээх нь утгагүй. Үүнийг Монгол улсад хийсэн гэр бүлийн хүчирхийллийн судалгаануудаас харж болно. Гэр бүлийн хүчирхийлэл давтан үйлдсэн, хорих ял сонссон, албадан сургалтад сууж байгаа хүмүүс улам нэмэгджээ. Монгол улсад гарч байгаа дийлэнх гэр бүлийн хүчирхийллийг үйлдэгч нь эрчүүд (Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, 2019; Үндэсний статистикийн хороо, 2020; Монголын криминологичдын холбоо, 2020) ажээ. Иймд албадан сургалтыг гэмшүүлэх, ухааруулах яриа лекц хэлбэрээр гэхээсээ сургалтад хамрагдаж байгаа хүмүүс өөр хоорондоо хамтран ажиллаж, өөрсдийн бий болгосон зан үйлүүдээр дамжуулан эдгэрэх, дахин гэр бүл, хамтын амьдралын аз жаргалыг мэдрэхэд нь туслах идэвхтэй, оролцооны хэлбэрээр зохион байгуулах хэрэгтэй байна.

ГБХ-д өртсөн эмэгтэйчүүдэд зориулсан “давал давах зан үйлийн” хөтөлбөр нь ГБХ үйлдэгч эрчүүдэд зориулсан эдгэрлийн хөтөлбөрийн эхлэл болох тухайд

Монгол улсад хийсэн судалгаанууд ГБХ үйлдсэн эрчүүдийн албадан сургалт үр дүнгүй байгааг илтгэдэг. Сэтгэл зүйн хувьд эдгээх, дахин нийгэмшүүлэх гэсэн сургалт үр дүнтэй эсэх нь дэлхий дахинд ч эргэлзээтэй. Тухайлбал, Роберт, Давис (1999) нар ГБХ үйлдсэн эрчүүдэд хийсэн сургалт, эмчилгээнүүд дундаас хамгийн үр дүнтэй байж болох хувилбарыг эмпирик байдлаар олж тогтооход хэцүү, хязгаарлагдмал байна гэж үзжээ. Гэхдээ ямар ч тусламж, үйлчилгээ авахгүй байгаа, хүчирхийлэл үйлдсэн эрчүүдээс тусламж, үйлчилгээ авч байгаа эрчүүд өөрсдийн амьдралаа эргэн харж, өөрчлөгдөх илүү магадлалтай (Julia C. Babcocka, Charles E. Greena, Chet Robie, 2002).

ГБХ-д өртсөн эмэгтэйчүүдэд зориулж ашигласан, зан үйл (ritual)-д суурилсан эдгэрэлтийн хөтөлбөрийг “хүчирхийлэгч” гэсэн ойлголтоор өөрийгөө тодорхойлолгүй, өөрийгөө ойлгох шинэ хандлагыг төлөвшүүлэн өөрчлөгдөхөд нь нөлөөлөх шинэ арга барил болгон ГБХ үйлдсэн эрчүүдэд ашиглах бололцоотой гэж үзэж байна. Зан үйл, тэр дундаа бидний өмнөх хэсэгт тайлбарласан “давал давах зан үйл”-д суурилсан “эмэгтэйчүүдийг чадавхжуулахад” (women empowerment) төвлөрсөн хөтөлбөрийг энд онцлон авахаар шийдлээ (Wozniak, Allen 2011). Энэ хөтөлбөр нь АНУ-н Монтана, Мичиган муж улсын түр хамгаалах байранд хүргэгдэн ирсэн ГБХ-д өртсөн эмэгтэйчүүдээс сайн дураар нь сонгон авч, 4 жилийн турш хэрэгжсэн байна.

Возниак, Аллен нар уг хөтөлбөрийг хэрэгжүүлж байхдаа бусад хохирогч эмэгтэйчүүдэд зориулсан судалгаануудыг шүүж, анализ хийжээ. Тэдний үзэж байгаагаар өөрийгөө “ГБХ-н хохирогч, амьд үлдэгч (survivor)” гэж тодорхойлж буй эмэгтэйчүүд аливаа хүчирхийллийн эсрэг сургалтад хамрагдаад ямар ч үр дүн, өөрчлөлтөд хүрч чадаагүй л бол эргээд хүчирхийлэл дүүрэн амьдралын хэв маягаа хүлээн зөвшөөрч, улам бүр өөрийгөө зүхэх хандлага нэмэгддэг байна. ГБХ-д өртсөн эмэгтэйчүүд фокус бүлгийн ярилцлагын үеэр өөрт тохиолдсон үйл явдлыг ярихыг хүсэхгүй байгаа байдал олон судалгаагаар батлагдсан бөгөөд энэ тухай ярих нь өөрийг нь “хохирогч” гэсэн мэдрэмжийг улам сануулж, хүчирхийлэл, айдасгүйгээр бие даан амьдрах чадваргүй гэсэн бодлыг нь улам бататгадаг (2011, хууд. 83). Хохирогч болсон түүхээ бусадтай хуваалцах нь эргээд эмэгтэйчүүд өөрсдийгөө ийм өрөвдөлтэй хувь тавилантай гэж итгэх нотолгоо болоод зогсохгүй ямар ч шинэ статус олж авч чадаагүй лиминал төлөвт нь орхисон байдаг.

Вознаик, Аллен нарын боловсруулсан зан үйл дээр тулгуурласан эдгэрлийн хөтөлбөр уг асуудлыг шийдвэрлэж чаджээ. Эмэгтэйчүүд бүр ижилхэн хүчирхийлэлд өртөж байсан гэдгээ мэдэж байгаа учир өөрсдийн түүхээ ярихыг хүссэн үедээ л ярих бөгөөд сургалтын зүгээс хэн ч тэднийг ярихыг шахахгүй. Сургалтын зүгээс оролцогч бүсгүйчүүдэд хохирогч гэдгээс өөр статус олж авах боломжуудыг нээж өгсөн бөгөөд их сургуульд оройн ангид бүртгүүлэх, шинэ ажил хийх эсвэл дуртай зүйлдээ цаг зарцуулах зэргээр шинэ статустай болж, өөрсдийгөө хэрхэн эергээр өөрчлөгдөн шинэ хүн болж буйгаа хоорондоо ярилцаж урам зориг авцгаах болжээ (2011, хууд. 89-90). Бүсгүйчүүд өөрсдийгөө хохирогч гэж тайлбарлахын оронд оюутан болсон тухайгаа, шинэ ажил нь ямар санагдаж байгаа талаар ярилцах замаар өөрсдийн шинэ статус, эрх чөлөөгөө ухамсарлаж, өнгөрсөнд болсон бүхнийг даван гарч шинээр амьдралд дахин төрж буйг нь илэрхийлэх хамтын зан үйлийг бүтээсэн байна. Энэ нь заавал шинэ зан үйл байх албагүй бөгөөд зарим бүсгүйчүүд эртний индианчуудын утаагаар ариусгах, шилэнд хүслээ бичээд далай руу шидэх, эерэг өөрчлөлт дээр төвлөрөн бясалгал хийх зан үйлийг сонгон хамтдаа хийж байжээ. Сургалтын зүгээс зөвхөн чиглүүлэг, туслалцаа үзүүлэхээс эдгэрлийн үйл явцад идэвхтэй оролцоогүй байна (2011, хууд. 90). Үр дүнгийн судалгаагаар энэ сургалтад хамрагдсан ихэнх эмэгтэй хүчирхийлэлтэй хосын харилцааг орхиж, зарим нь хостойгоо тус сургалтад хамрагдахыг хүсэж буйгаа илэрхийлжээ. Мөн сургалтын үеэр олж авсан шинэ статусаа хөгжүүлж, ахиц дэвшил гаргаж байгаа тухай бичсэн байна.

Тус өвөрмөц судалгаа нь хохирогч бүсгүйчүүдэд зориулсан зан үйлийн давал давахад суурилсан эдгэрлийн зан үйлийг харуулж байгаа боловч давхар тэдний өмнө тулгарч байсан экзистенциал түгшүүр, оршихуйн хямралыг даван туулж, өөрийгөө хуурч байсан ойлголт, статусаасаа салахад нь тусалсан байдаг. Хохирогчдын байгаа лиминал төлөв нь экзистенциал түгшүүр, оршихуйн хямралтай, шинээр статус олж авах, завсрын үеэ давж гарах нь өөрийн эрх чөлөө, хариуцлагыг ухамсарлан, өөрийгөө хуурч буй байдалтайгаа нүүр тулж байгаатай таардаг. Уг сургалт нь бүсгүйчүүд хүчирхийлэлтэй харилцааг орхиж, шинэ статустай болоод зогсолгүй тэдний оршихуйн асуудлаа даван туулахад нь тусалсан гэж ойлгож болно.

Яг үүнтэй ижил ГБХ үйлдсэн эрчүүдийн өмнө тулгарч буй оршихуйн асуудал, хуурамч итгэл, өөрийгөө хуурч буй байдлыг зогсооход зориулсан эдгэрлийн сургалтыг бүтээх бололцоотой юм. Ингэхийн тулд бид зарим ГБХ-г бий болгож буй оршихуйн асуудлыг ойлгох, шинжлэх шаардлагатай байна.

Статусын шилжилт ба экзистенциал шийдвэр

Геннеп, Түрнер нарын ярьж буйгаар лиминал байдал нь нэг статусаас нөгөө статус руу шилжих шилжилтийн үе юм. Энэ шилжилтийн үе нь айдас, түгшүүр, санаашралаар дүүрэн байдаг. Экзистенциализмд яригддаг хүн өөрийгөө хэн байхыг тодорхойлох экзистенциал шийдвэр гаргахын өмнөх нөхцөл байдал нь лиминал байдалтай яг цав тохирно. Тэгвэл Сартрын экзистенциал философи бидэнд статусын шилжилтийн үед тулгарч буй экзистенциал нөхцөл байдал, ГБХ-н уг сурвалжийн тухай юуг хэлж чадах вэ?

Дээр дурдсан асуултад хариу өгөхийн өмнө, экзистенциализмд хүний оршихуй, сонголт, хариуцлагыг юу гэж ойлгодог болохыг тайлбарлахаас эхэлье. Сартрынхаар хүний ухамсар (consciousness) нь ертөнц дээр байдаг ямар нэг зүйл бус, өөртөө юуг ч агуулдаггүй, үргэлж ямар нэг зүйл рүү чиглэсэн байдаг гэж ойлговол ухамсрын хүртэж буй бүх зүйлс түүнээс өмнө оршин байдаг. Энэ санаагаа Сартр “оршихуй нь мөн чанарынхаа өмнө байдаг” гэж тодорхойлжээ (Sartre, 2003 хууд. 615–628). Өөртөө байгаа ахуйн (being in itself) буюу ухамсрын хувьд чиглэх боломжтой утгуудыг өгч байгаа ертөнц нь нэг нэгнээсээ үл ялгагдах оршихуй (undifferentiated being), өөрчлөгддөггүй, юунаас ч хамааралгүй оршдог. Цаг хугацаанд хүлэгддэггүй. Ирээдүй, өнгөрсөн гэж байхгүй оршиж буй бүх зүйлс үүнд орно. Шалтгаангүйгээр оршдог. Өөрөөсөө өөр зүйл байж чаддаггүй. Боломж, тасалдалт, өөрчлөлт, түр зуур зэрэг нь үүнд багтдаггүй. Жишээ

нь сандлыг сандал болгож байгаа мөн чанар, хэлбэр нь үл дасалдах шинжтэй, өөрчлөгддөггүй бөгөөд оршин тогтнохын тулд өөр зүйлээс хамааралгүй бие даасан байж чаддаг.

Энэ утгаараа ертөнц дээр байгаа бүх зүйлс өөртөө байгаа ахуй болдог. Гэтэл ухамсар ийм хэлбэрээр оршиж чаддаггүй ба өөртөө байгаа ахуйгаас хамаармал оршдог. Хүний ухамсар нь оршин буй байдлаа ухарч, өөрийгөө хүссэнээрээ тодорхойлох боломжийг олгодог “юу ч биш”-ийг агуулдаг. Энэ нь хүнийг туйлын эрх чөлөөтэй болгодог ч мөн түүнд хариуцлагыг үүрүүлдэг. Ухамсар нь өөртэй байгаа ахуйтай юугаараа ч адилгүй байгаагаа ухамсарлаж, өөртөө байгаа ахуйг үгүйсгэх (negation) замаар өөрийгөө тодорхойлдог (Сох, 2008). Жишээ нь би сандал биш, чулуу биш, энэ ертөнц дээр байгаа ямар ч объектод адилхан биш гэдгээ ухамсарладаг трансценденц (transcendence) чадвартай.

Трансценденц нь өөрийг нь объект мэтээр тайлбарлаж буй баримтуудаас (facticity) чөлөөлж чанагш болж буй тэр үйл явцыг хэлдэг. Өөртөө байгаа ахуй трансценденц хийх замаар өөрийгөө тодорхойлох гэж ямагт хичээдэг. Өөрөөр хэлбэл хүний оршихуйд ямар ч тогтсон утга учир, зүй тогтол байдаггүй бөгөөд түүнийг тойрон хүрээлж буй ертөнцтэй харилцахдаа олж авсан утгуудаараа хэн байхаа тодорхойлдог. Үүнээс өмнө хүний оршихуй ямар нэг утгатай байдаггүй. Энгийнээр юу ч биш байдаг. Ухамсар өөрийгөө тодорхойлохын тулд, өөрийнхөө төлөө ахуй байхын тулд үйлдэл (action) хийх шаардлагатай болдог. Сартрынхаар үйлдэл хийх гэдэг нь сонголт (choice) хийхтэй ижил утгатай. Өөрийнхөө төлөө ахуйд объект байх урьтал мөн чанар байхгүй учир тэрээр сонголт хийх бүрэн эрх чөлөөтэй (freedom). Хийж буй сонголтуудын үр дүнгээр тухайн ахуй буюу хүн хэн байх нь тодорхойлогддог. Хүний оршихуй бол өнгөрснөөр тодорхойлогдохгүй хэр нь хараахан биелээгүй байгаа ирээдүйд (temporality) хийх сонголтуудаар бодитой болно. Аливаа хүн, ГБХ үйлдсэн эрчүүд гэлгүй бүх хүн өөрийн хэн байхыг тодорхойлох эрх чөлөө заяагдмал байдаг. Энэ эрх чөлөөгөө ухамсарлах нь ГБХ үйлдсэн эрчүүдийн хувьд эдгэрлийн замыг сонгох, өөрийгөө өөрчлөх экзистенциал шийдвэр гаргах гол суурь болох юм.

Гэр бүлийн хүчирхийлэлд хамаарах экзистенциал эрх чөлөө ба хуурамч итгэлийн нөлөө

Энд бид Сартрын “Ахуй ба юу ч биш” зохиолд гардаг экзистенциал философид хүний ахуйн мөн чанартай уялдан гарч ирдэг хуурамч итгэл ба аутентик байдал гэсэн ойлголтуудыг нь хүн өөрийгөө хэрхэн ойлгож, өөрийгөө хэн бэ гэдгийг тодорхойлоход чухал үүрэгтэй, хүний хийж буй үйлдлүүдийг чиглүүлж байдаг болох тухай авч үзнэ. Ямар ч нөхцөл байдалд гаргасан шийдвэртээ хариуцлага хүлээх ёстой эрх чөлөө өөрийнхөө төлөө оршихуй буюу хүнд байдаг. Үүнээс экзистенциал эрх чөлөөний үндэс тавигддаг. Өөрийгөө ямар нэг объект гэдгийг үгүйсгэх уг сурвалж нь энэ эрх чөлөөтэй холбоотой. Өөрийнхөө төлөө ахуй үүнийг ухамсарлаж харамсаж, гэмшилгүйгээр, хийсэн сонголтынхоо хариуцлагыг үүрч, экзистенциал эрх чөлөөгөө хүлээн зөвшөөрч аутентик (authenticity) байж чаддаг.

Аутентик байдлын антитезис бол “хуурамч итгэл” (bad faith) юм. Хүн өөрийгөө эрх чөлөөтэй гэдгийг ухамсарлах үед энэ нь дур зоргоороо байдлаас өөр болохыг анзаардаг. Эрх чөлөөтэй хийж буй сонголт бүр нь үр дагавар, хариуцлага (responsibility), тодорхойгүй байдлыг дагуулж байдаг учир сэтгэл түгшил (anxiety), таагүй байдлыг бий болгож, энэ эрх чөлөөнөөсөө татгалзахыг эрмэлзэж, сонголтгүй сонголт хийсэн мэтээр өөртөө итгүүлдэг. Үүний шалтгаан нь хуурамч итгэл байдаг (2003, хууд. 86-113). Ичих, харамсах зэрэг мэдрэмж нь тухайн хүний үйлдлийг бусад чөлөөтэйгөөр тайлбарлах үед гарч ирдэг. Бид бусдын харц (Le Regard), хараа хяналтын доор байж, тэдний тавьсан шаардлага, хүлээлтэд нийцэх гэж эрмэлзэх үедээ дээр дурдсан аутентик байдлаа алддаг. Бусдаас олгож буй сонголт нь өөрийнхөө төлөө ахуй нь трансценденталь субъектив байдал буюу экзистенциал эрх чөлөөнөөс бус нийгэм, бүлгийн зүгээс тогтсон трансценденталь субъектив байдлаас урган гардаг. Хүний трансценденталь

субъектив байдал нь бусдын трансценденталь субъектив байдлаас буюу бусдын харцнаас болж хэрэгжих боломжгүй болдог (2003, хууд. 301–341). Энгийнээр хэлбэл бид бусадтай, нийгэмтэй харилцах үедээ тэдний хувьд объект болж хувирдаг. Тухайн хүний боломж нь бусдаар хязгаарлагдаж, түүний үйлдэл бусдаар шүүгдэж байдаг. Энэ ахуйг Сартр бусдын төлөөх ахуй (being for others) гэж нэрлэсэн. Жишээ нь, нөхөр нь эхнэртээ миний ингэж амьдарч байгаа нь чамаас болсон гэж хэлэх үедээ аль хэдийн объект болж, аутентик байдлаа алдсан байдаг.

Бусдын төлөөх ахуй бол “сонголтгүй сонголт хийсэн гэж итгэдэг”, өөрийг нь тодорхойлж буй баримтуудаас (гадаад төрх, гарал угсаа, нийгмийн статус, эд хөрөнгө, бусдаас өөрийг нь үнэлж буй үнэлгээ гэх мэт) ирэх дарамтыг эсэргүүцэх, нөгөө талдаа эрх чөлөөгөө хэрэгжүүлэхийг эрмэлзэж байгаа зөрчил дунд байгаа ахуйг илэрхийлдэг. Сартрын хэлж байгаагаар хайр сэтгэлийн харилцаа хүртэл энэ дарамтыг тодорхой утгаараа харуулдаг бөгөөд бусдаар хүлээн зөвшөөрөгдөх, жинхэнэ эрх чөлөөтэй байх нь хэн нэгнээс хамаармал байх, хэт тодорхой байдалдаа зэрэгцэн орших аргагүй байдаг ажээ (2003, хууд. 474–494).

Хуурамч итгэл нь сул хуурамч итгэл, хүчтэй хуурамч итгэл гэж хоёр хуваагдана. Сартр сул хуурамч итгэлийг өөрөөр (faith of bad faith, weak bad faith) гэж нэрлэдэг. Ухамсар бүрэлдэн хөгжиж байх үе буюу хүүхэд насанд юунд итгэх ёстой тухай итгэл үнэмшил давхар бүрэлддэг. Үнэн худал эсэхийг нь шалгах шаардлагагүй, эргэлзээгүй мэт санагддаг, мэдээжийн бүх хүн хүлээн зөвшөөрсөн зөнгөөрөө итгэдэг итгэл үнэмшлүүд энд орно. Үүний тусламжтайгаар хүн өөрийгөө хэн байх, ямар зан ааштай, юу хийх хэрэгтэй вэ? гэдэгтээ итгэх үндэстэй болж эхэлдэг. Сул хуурамч итгэлийн суурин дээр хуурамч итгэл бүрэлдэн бий болдог (2003, хууд. 86–116). Хүчтэй хуурамч итгэл нь (strong bad faith) бүрэлдэн бий болсон хуурамч итгэлийг улам батжуулах, эргэлзээгүй болгоход чиглэсэн байдаг. Өөрөөр хэлбэл хуурамч аутентیکیг үүсгэх өөрийгөө хуурах үйлдлийг идэвхтэйгээр үйлдэж, хариуд нь эрх чөлөөнөөс ирэх түгшүүрээс ангижрах ажээ (2003, хууд. 102–105).

Сартрынхаар хуурамч итгэл бол сөрөг утгатай ойлголт биш. Үүний тусламжтайгаар л өөртөө байгаа ахуй эрх чөлөөгөө ухамсарлаж, аутентик байхаар шийдэж, амьдралынхаа утга учрыг бүтээн амьдардаг. Ийм сонголт хийхээр зэхэж буй ахуйг тэрээр нөхцөл байдал дахь ахуй (being in situation) гэж нэрлэсэн байна. Энэ ахуй бол өөрийнхөө төлөө ахуйн нэг хэлбэр бус, сонголт хийсэн үүгээрээ мөн чанар нь тодорхойлогддог бие даасан, тусдаа ахуй байдаг. Хүн цаг үргэлж аутентик байж чаддаггүй учир бүх хүн хуурамч итгэлтэй байдаг. Жишээ нь хэн нэгэн би өөрийгөө олсон, би энэ мөн байна гэж хэлэх үедээ хуурамч итгэл дотор л байдаг. Учир нь эхлэл хэсэгт дурдсанчлан хүний ахуйд тогтсон утга учир байхгүй, юу ч биш учир сонголт бүр нь түүний мөн чанар, хэн байхыг өөрчилдөг. Иймд хүн аль болох аутентик байхыг эрмэлзэж, өөрийн хийсэн сонголтдоо эзэн байж, ямар ч үр дагаврыг хүлээн авахыг эрмэлзэх хэрэгтэй болдог.

Сартрын ашигласан түр зуур (temporality), ухамсар, үгүйсгэл (negation), трансценденц, бусад, хуурамч итгэл зэрэг ойлголтууд нь өөртөө байгаа ахуйн шинж бус ертөнцтэй харьцах явцад хүний оршихуйг бодитой болгох феноменууд байдаг. Бидний санал болгож байгаагаар хүчирхийлэл ч мөн өөртөө байгаа ахуйтай харьцах замаар бий болсон хүний оршихуйг бүрэлдүүлэгч феномен мөн. Энэ феномен нь үл ялгагдах ахуйгаас (undifferentiated being), ялгагдах ахуй (differentiated being) болохыг эрмэлзсэн идэвхтэй үйлдлээс бий болдог. Ингэхдээ бусдыг үгүйсгэх замаар хэрэгжилтээ олдог (2003, хуудас. 21–57). ГБХ нь гэр бүлийн гишүүд нэгнийхээ трансцендентал субъектив байдлыг үгүйсгэх, мөн өөрийгөө хүлээн зөвшөөрүүлэх гэсэн өөрийгөө хуурах үйлдлээс бий болдог гэдгийг энд авч үзнэ. Дээр өгүүлсэн санааг Симон дэ Бовуар “Дайвар хүйстэн” зохиолдоо тодорхой бичжээ. Залуу хөвгүүд нэгэнтэйгээ ноцолдох, зодолдох, нэр төрөө доромжлуулах үедээ гараа зангидах, хүч чадлаа харуулах, үзэл бодлоосоо няцалгүй бусдаар шүүмжлүүлэх, магтуулах, хариуцлагатай үүрэг даалгаварт оноогдох үедээ

өөрсдийгөө объект гэж мэдэрдэггүй. Түүнийг объект мэт харьцах гэж оролцсон бүхэнтэй хүү тэрсэлдэхэд бэлэн байдаг (Бовуар, 2010). Хүчирхийлэл нь хүн өөрийгөө объект бишээр мэдэрч, аутентик байх боломж олгодог. Гэвч бүх хүчирхийлэл ийм аутентик байхад чиглэдэггүй.

Хуурамч итгэлийг “хүчтэй хуурамч итгэл (strong bad faith)” болгоход чиглэдэг хүчирхийллийн төрлүүд байдгийг энд дурдах хэрэгтэй. Дээр дурдагдсан хөвгүүдийн жишээн дээр тайлбарлавал хөвгүүдийн хүчирхийлэл үйлдэж байгаа зорилго нь аутентик байдал руу чиглэдэг бол гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж байгаа зорилго нь хуурамч итгэлийг улам хүчтэй болгоход чиглэдэг. Өөрөөр хэлбэл гэр бүлийн орчинд үйлдэгдэж байгаа хүчирхийлэл нь нийгмийн хэм хэмжээ, бусдын зүгээс тавигдаж буй трансцендентал субьектив байдлыг эсэргүүцэхэд чиглэсэн бус хайр, гэрлэлт дээр бий болсон урт хугацааны хамтран амьдралын хүрээнд субьектууд нэгнийхээ хувьд нөхцөл байдал дахь ахуй (being in situation) гэдгийг нь үгүйсгэж байгаа өөрийгөө хуурах үйлдлээс бий болдог.

ГБХ нь нэг талаараа өөрийн оршихуйг батлах, объект биш идэвхтэй үйлдэгч гэдгээ мэдрэх, өөрчлөлт бий болгох гэсэн арга зам мэт харагддаг. Энд хүлээн зөвшөөрүүлэх ч мөн багтана. Хамгийн ихээр өөрийгөө хүлээн зөвшөөрүүлэхийг хүсэж байгаа субьект руу чиглэсэн эрэмбэ дараатай хүчирхийлэлд ГБХ багтдаг. ГБХ нь нийгмийн амьдралд, хувь хүний амьдралд үйлдэгдэж байгаа хүчирхийллүүдээс үүгээрээ ялгаатай. Гэр бүлийн орчинд хамгийн ихээр өөрийгөө хүлээн зөвшөөрүүлэхийг хүсэж байгаа хүн рүү хүчирхийлэл нь чиглэдэг. Монгол улс болон олон улсад хийгдсэн хүчирхийллийн тоон судалгаануудаас харахад ГБХ-н дийлэнх хохирогч нь эмэгтэйчүүд тэр дундаа эмэгтэй хамтран амьдрагч, найз охин, хууль ёсоор гэрлэсэн эхнэр нь байдаг (НҮБ-ын Хүн амын сан, 2017).

Нөгөөтээгүүр судалгаанд эрэгтэйчүүд ихэвчлэн хүчирхийлэгч, эмэгтэйчүүд ГБХ-н хохирогч байх нь элбэг байдаг. Эрчүүд өөрийн үйлдсэн гэр бүлийн орчин дахь хүчирхийлэлдээ гэмшиж, өөрийгөө буруутгах, хамтран амьдрагчаа буруутгах, өөрийн үйлдлээр дамжуулан гэр бүлийн гишүүдээ эрх мэдэлдээ байлгаж, өөрийгөө хүлээн зөвшөөрүүлэхийг хүсдэг. Тэдний хувьд энэ бол сонголтгүй сонголт, үүнээс арга зам үлдээгүй гэж тэд итгэдэг. Энэ байдал нь тэд “хүчтэй хуурамч итгэл”-тэй байгааг гэрчилнэ. Эрэгтэйчүүдийн хувьд ГБХ бол өөрийгөө хүлээн зөвшөөрүүлэх, амьдралаа утга учиртайгаар мэдэрч чадахгүй байгаа санаашралаас, эршүүд байдлаа боломжит бүх аргаар нь мэдрэхийг хүссэн хуурамч итгэлээс бий болдог.

Лиминал байдал ба экзистенциал эрх чөлөөний холбоо хамаарал

Сартрын үзэж байгаагаар хүний мөн чанар нь оршихуйнхаа дараа байдаг (Sartre, 2003 хуудас. 615–628). Хүнийг төрөх үеэс нь түүнд хүчирхийлэгч, хохирогч эсвэл эмэгтэй, эрэгтэй гэсэн утга өгөгдөөгүй байдаг бөгөөд тэрээр нийгмийн гишүүн болсны дараа л эдгээр утгыг өөриймшүүлж авдаг. Өсөж торних явцдаа бид бусдын хүлээлт, харц доор шийдвэр гаргаж, янз бүрийн нийгмийн нормуудад суралцдаг. Гэвч эдгээр норм, нийгмийн харилцаанаас бий болсон утгууд (хүчирхийлэгч, хохирогч) нь бүгд субьектив зүйл бөгөөд хэзээд өөрчлөгдөх боломжтой. Энгийнээр бид утгыг бүтээдэг болохоос ертөнц дээр объектив, бие даасан утга гэж байхгүй. Үүнээс үүдэн хүн хязгааргүй эрх чөлөөтэй болдог. Энэ эрх чөлөөтэй байдал нь давхар асар их хариуцлагыг өөртөө агуулж байдаг. Гаргасан шийдвэр бүрийн хариуцлагыг та өөрөө хүлээнэ. Хариуцлага ямагт түгшүүр, айдас дагуулдаг.

Томоохон уй гашуу тохиолдсон (салалт, ажилгүйдэл гэх мэт...) үед л хүн энэ эрх чөлөөгөө хамгийн ихээр мэдэрдэг бөгөөд үүнээс зугтаахын тулд хүчирхийлэгч дээрээ очих эсвэл хүчирхийлэл үйлддэг. Учир нь хариуцлага түүнийг зодсон хүнд, эсвэл зодуулсан хүнд шилждэг. Өөрөөр хэлбэл хүчирхийлэгч, хохирогч байх нь экзистенциал нөхцөл байдалтайгаа нүүр тулснаас амар байдаг ажээ. Дахин хариуцлага хүлээх хэрэггүй ба бусдын эрхшээлд байх нь зовууртай боловч эрх чөлөөтэй байхын зовлонгоос таатай. Сартрын санал болгож байгаагаар экзистенциал шийдвэр гаргах боломж нь хүнд өөрийгөө хэн байхыг шийдэх эрхийг олгодог. Энэ

утгаараа экзистенциал шийдвэр нь муу зүйл биш. Харин ч хэн байхаа шийдэх, шинэ статус руу шилжих боломж олгодог. Хэн байхаа шийдэх үедээ бид лиминал төлөвөөс хамтран ажиллах (cooperation) шат руу дэвшдэг. Тэгж чадаагүй тохиолдолд лиминал төлөвтөө үлддэг.

Экзистенциал шийдвэр гаргахын өмнөх нөхцөл байдал нь Геннеп, Түрнер нарын тодорхойлсон лиминал төлөвт байх үеийн нөхцөл байдалтай таардаг. Тухайн хүний гаргасан экзистенциал шийдвэр нь тогтсон утгыг хүлээн зөвшөөрөх бус, сэтгэлийн дуудлагадаа хариулсны үр дүнд бий болсон цоо шинэ утга учир байдаг¹⁰. Утга учиргүй ертөнцөд утга учрыг бүтээж амьдрах эр зоригтой байх хэрэгтэй болдог. Энэ эр зоригийг бид зан үйл (rituals) болон тэдгээрээс бидэнд төрж буй бодрол, эргэцүүлүүдээс олж авах боломжтой. Возниак, Аллен нарын хэрэгжүүлсэн эдгэрлийн сургалт шиг эрчүүдэд зориулсан экзистенциал эдгэрлийн сургалт байж болох онолын үндэс байна. Нийгэмд гарч буй ГБХ шалтгааныг ойлгох, хүчирхийлэгчийг шууд эрүүгийн хариуцлага хүлээлгэн, яллахаас өмнө үзүүлж болох тусламж, үйлчилгээг бий болгох, тэдний нүүр тулж буй сорилтуудыг эрүүл аргаар даван туулж, лиминал байдлаас гарахад нь туслах, хийсэн үйлдлийнхээ хариуцлагыг ойлгож, утга учиртай амьдрахад нь туслах хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага нэгэнтээ бий болжээ.

Дүгнэлт

Гэр бүлийн хүчирхийллийн тухай асуудал нийгмийн эмзэг сэдэв хэвээр байна. Хүчирхийллийн эсрэг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь хохирогчид түлхүү чиглэсэн, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн эрчүүдийг оролцоонд тулгуурлаж дахин нийгэмшүүлэх санаачлага, сургалт, хөтөлбөргүйгээр үргэлжилж байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн эрчүүд “хүчирхийлэгч” гэсэн статусаас ангижирч, дотоод экзистенциал нөхцөл байдлаа ухамсарлаж, сэтгэл зүйн хувьд эдгэрэн, өөрийгөө ойлгох, амьдралыг харах өөр хандлагатай болж, нийгмийн амьдралд шинэ байр суурьтай оролцоход давал давах зан үйл эерэг нөлөө үзүүлж болохыг хохирогчид зориулсан зан үйлийн эдгэрлийн сургалт харуулж байна.

Ном зүй

1. Allen, Danielle F. Wozniak Karen Neuman. (2011). “Ritual and Performance in Domestic Violence Healing: From Survivor to Thriver Through Rites of Passage.” *Cult Med Psychiatry* 80-101.
2. Arnold, van Gennep. (1960). *The Rites of Passage*. Trans., Gabrielle Caffee Monika Vizedom. Chicago: University Press.
3. Cox, G. (2008). *The Sartre Dictionary*. Bloomsbury Publishing.
4. Julia C. Babcock, Charles E. Greena, Chet Robieb. (2002). “Does batterers’ treatment work? A meta-analytic review of domestic violence treatment.” *Clinical Psychology Review* 1023–1053.
5. Sartre, Jean-Paul. (2003). *Being and Nothingness*. Hazel Estella Barnes.
6. Taylor, Robert C. Davis Bruce G. (1999). “Does Batterer Treatment Reduce Violence? A Synthesis of the Literature.” *Victim Services Research* 69-93.
7. Turner, Victor. (1969). *The Ritual Process*. Chicago: Aldline.
8. Бовуар, С. (2010). *Дайвар хүйстэн*. Улаанбаатар: Урлах Эрдэм.
9. Монголын криминологичдын холбоо. (2020). *Монгол Улсад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх нь. Судалгааны тайлан*. Улаанбаатар.
10. НҮБ-ын Хүн амын сан. (2017). *Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаа*. Улаанбаатар.

¹⁰ Өөрийгөө өмнө нь харж байгаагүй өнцгөөрөө олж хардаг. Жишээ нь хүчирхийлэгч байхаа больж өөрийн сэтгэлийн шархтай нүүр тулж, эдгэрэхийг эрмэлзэж, өөрийнхөө хүссэнээр амьдарч эхлэх.

11. Хүчирхийллийн эсрэг үндэсний төв. (2019). Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилт. Мониторинг тайлан. Улаанбаатар.
12. Үндэсний статистикийн хороо. (2020). Гэр бүлийн хүчирхийлэл. Улаанбаатар

An Existentialist Analysis of Coercive Training and Recovery Behaviors for Men Perpetrating Domestic Violence

This article explores a potential approach to help men who have perpetrated domestic violence move beyond their identity as "abusers," recover psychologically, and adopt a new perspective on themselves and their place in society. The positive impact of Rites of Passage, particularly those involving prayer rituals and fostering healing through "communitas," is discussed. Furthermore, this approach is analyzed from anthropological, social work, and existential philosophical perspectives, with an emphasis on how such group-based interventions may support men in reducing domestic violence and transforming their lives.